

2025 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1, 92.2 дахь хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк” ХК (цаашид “Банк” гэх)-ийн дүрмийн 8 дугаар 8.11.20 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Банкны холбогдох этгээд болох “Ти Ди Би Секьюритис ҮЦК” ХХК-тай энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлтэй “Хамтран ажиллах ерөнхий гэрээ” байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ, хэлцэл болон холбогдох бусад баримт бичигт Банкныг төлөөлөн гарын үсэг зурах, холбогдох этгээдэд дамжуулан итгэмжлэл олгох болон шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОПША